



Даатгалын нөхцөл

Та даатгалын нөхцөлтэй танилцана уу

ТАНЫ ДААТГАГДСАН ЭРСДЭЛҮҮД		ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ
1	Байгалийн эрсдэл	3,000,000 хүртэл
2	Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэл	
3	Мал амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл	
4	Гуравдагч учруулах эрсдэл этгээдийн	
5	Ахуйн эрсдэл	
Даатгалын хураамж буюу таны төлөх дүн		₮ 30,000

НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ НӨХЦӨЛ

- Даатгагч нь гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөрийг олгоогүй бол Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцон Даатгуулагчид олгоно.
- Даатгалын тухай хуулийн 8.7-д заасныг үндэслэн Даатгагчийн Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан бусад зардлын хамт буруутай этгээдээс нэхэмжлэх Даатгуулагчийн эрх нь Даатгагчид шилжинэ.
- Даатгагчийн санаачилгаар нөхөн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож шийдвэрлэж болно.
- Даатгалын гэрээний хугацаанд даатгалын гэрээгээр олгогдох нөхөн төлбөрийн нийт хэмжээ нь даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- Даатгагч даатгалын гэрээний нөхцөлийн дагуу эмчилгээ, үйлчилгээ эхэлсэн өдрөөс эхлээд цаашид эмчлүүлэх шаардлагагүй гэдгийг эмнэлгийн зүгээс тогтоосон эсвэл даатгалын гэрээний хугацаа дуусах хүртэлх хугацааны зардлыг төлнө.
- Даатгуулагч даатгалын тохиолдол бүр нэг удаа нэхэмжлэл гаргах эрхтэй.

НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ

- Гэрээгээр хамгаалагдаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол;
- Даатгуулагч ослын талаар нэн даруй эрх бүхий байгууллагад мэдэгдэж ослын шалтгаан нөхцөлийг тогтоолгоогүй, шалтгаан нь тодорхойгүй буюу нотлох боломжгүй;
- Гэрээний хүчин төгөлдөр хугацаанаас өмнө болон дараа нь үүссэн хохирол;
- Энэхүү гэрээний 4.2-д заасны дагуу даатгалын тохиолдлын тухай Даатгагчид мэдэгдээгүй, учирсан хохирлыг нотлох, шалтгааныг тогтоох баримт, дүгнэлт, нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай бүрэн гүйцэд баримт бичиг, мэдээ мэдээллийг Даатгагчид ирүүлээгүй;
- Даатгуулагч даатгалын тохиолдол бий болох буюу бий болохуйц нөхцөл орчныг бүрдүүлсэн, ихэсгэсэн, түүнчлэн мэдэгдэж буй буюу мэдэх боломжтой эрсдэлээс зайлсхийгээгүйгээс учирсан хохирол;
- Даатгуулагч буруутай этгээдээр хохирлоо нөхөн төлүүлсэн, төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан бол уг шийдвэрт заасан хэмжээгээр эсхүл буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах Даатгагчийн эрхийг Даатгуулагч ямар нэгэн байдлаар шууд болон шууд бусаар хязгаарласан;
- Халдварт өвчин түүний үр дагавраас үүдсэн хохирол (Зөвхөн цар тахал, коронавирусээр хязгаарлагдахгүй).
- Даатгуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтойгоор зөрчсөн тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй.